

Бизнес төлөвлөгөөний 2022 оны хэрэгжилтийн тайлан

2022.12.19

Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж	Гүйцэтгэл 11 сарын дүгээр 30	Хэлтсүүдээс ирүүлсэн Биелэлтийн хувь	Хяналт, мониторингийн үнэлгээ
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Биржийн зах зээлийн зохицуулалт, эрх зүйн орчинг сайжруулах										
Зорилт 1.1. Биржийн зах зээлийг боловсронгуй болгох замаар холбогдох хууль, журам, төрийн бодлого төлөвлөлтийн харилцан үйлдвэр хамтын ажиллагааг хангах замаар холбогдох бий болгоно.										
1.1.1	Холбогдох төрийн байгууллагын зохицуулах журмын уялдаа холбоог хангах санал боловсруулж, хэрэгжүүлэх;	Хувиар	Биржийн үйл ажиллагааг зохицуулагч байгууллагын түр журам шинэчлэгдсэн байна	20%	80%	I-IV	ЗСХ	Биржийн үйл ажиллагаанд баримталж ажиллах дүрэм, журмыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд нийцүүлэн мөрдөж ажиллаж байна.	100%	100%
1.2. Биржийн үйл ажиллагааны дүрэм, журмыг шинэчлэн найруулж, олон улсад мөрдөгддөг зарчим болон стандартыг өөрийн улсын онцлогт нийцүүлэн боловсруулна.										
1.2.1	Биржийн одоогийн мөрдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийн үнэлгээг гаргаж, шинэчлэн боловсруулж, мөрдөх;	Хувиар	Эрх зүйн баримт бичгийн төсөл	50%	80%	I-II	ЗСХ, ТТЭУХ, ЦХАХХ, ГБХ, АЗЗХХ	Биржийн үйл ажиллагаанд дүрэм, журам мөрдөгдөж байгаа бөгөөд үүнээс Хөдөө аж ахуйн биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох журам, Клиринг төлбөр тооцооны журмын хэрэгжилтэд дотоод, хяналт мониторингийн үйл ажиллагаа хийж, зөвлөмж өгч, хэрэгжилтийн хангуулан ажилласан. ТТЭУХ-ийн хэрэгжүүлэх клиринг, төлбөр тооцооны журам, хавсралтаар ХХАГ, нэхэмжлэх, дэнчин буцаах хүсэлтийг Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулсан. Мөн Байнгын гишүүний Клирингийн эрхийн гэрээг боловсруулж, батлуулсан. Гүйцэтгэх захирлын 2022.03.03-ны өдрийн А/33 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар Арилжааны журам, хоёрдугаар хавсралтаар Хөдөө аж ахуйн биржээр арилжсан бараа, түүхий эдийн тодорхойлолт олгох журам, 2022.4.17-ны өдрийн А/37 дугаар тушаалаар Гишүүнчлэлийн журмыг, Хяналт, шалгалтын журам, Гүйцэтгэх захирлын 6 дугаар сарын 24-ний өдрийн А/64 дугаар тушаалаар Хүний нөөцийн бодлогын баримт бичиг, "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэх үйл ажиллагааны журам"-ыг хэлэлцүүлж, 2022 оны 6 дугаар сарын 13-ны өдөр А/57 дугаар тушаалаар тус тус шинэчлэн батлуулсан.	100%	100%
1.2.2	Биржээр арилжигдах "Фьючерс гэрээ"-ний арилжаа, клиринг, төлбөр тооцоо болон дагалдах журам, холбогдох гэрээний төслийг боловсруулах;	Хувиар	Эрх зүйн баримт бичгийн төсөл	20%	80%	I-IV	ТТЭУХ, АЗЗХХ, ГБХ, ЦХАХХ, ЗСХ,	Клиринг, төлбөр тооцооны журамд фьючерс гэрээний клиринг, төлбөр тооцоо хийх зохицуулалтыг хамтатган оруулж найруулан, батлуулсан. Журам боловсруулагдаж батлагдсан ба цаашид сайжруулах шаардлагатай гэж үзвэл төсөл хэлбэрээр эрх зүйн актыг боловсруулах боломжтой. /Клиринг, төлбөр тооцооны журманд эхний байдлаар шаардлагатай зүйл заалтууд тусгагдан батлагдсан тул хэлтсийн зүгээс 100% дууссан/	100%	70%
1.2.3	Агуулахын стандарт, техникийн шаардлагыг шинэчлэх санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх;	Тоогоор	Стандартын баримт бичиг	0	1	I-IV	ГБХ	Стандартын төсөлд төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, олон нийтээс ирүүлсэн саналыг нэгтгэн боловсруулж, 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Стандарт хэмжилзүйн газрын Техникийн хорооны хурлаар 100 хувийн саналаар дэмжигдсэн. Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/90 дугаар тушаалаар байгуулагдсан малын гаралтай бараа, түүхий эдийн бэлтгэл, хадгалалтад тавигдах шаардлагуудыг тогтоох стандарт боловсруулах, батлуулах саналаа эрх бүхий этгээдэд хүргүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн төлөөлөл ХААИС-ийн багш нар, Стандарт хэмжилзүйн газрын ахлах мэргэжилтэн, Дэлхийн банкны МААЭЗЭН төслийн Малын эрүүл мэндийн зөвлөх зэрэг 5 хүнтэй байгуулсан Ажил гүйцэтгэх 22/12, 22/13, 22/17, 22/19, 22/28, тоот гэрээний хэрэгжилтийг гаргаж гэрээ дүгнэх акт үйлдсэн.	100%	100%

1.2.4	Бараа, түүхий эдийн чанарын баталгаажуулалтын шаардлагатай техникийн баримт бичгүүдийг боловсруулах, бүрдүүлэх;	Тоогоор	Агуулахын үйлчилгээг баталгаажуулах схем зураглал	0	1	I-IV	ГБХ	ISO/IEC 17065:2012 Тохирлын үнэлгээ – Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээг баталгаажуулах байгууллагад тавих шаардлага” стандартын хүрээнд Гишүүнчлэл бүртгэлийн хэлтсийн 5 мэргэжилтэнг M1, M2 баталгаажуулалтын мэргэшсэн шинэжээчийн сургалтад хамруулж, тухайн стандарттай хамааралтай техникийн бичиг баримтуудыг боловсруулан бүрдүүлж, Стандарт хэмжил зүйн газрын Техникийн хорооны хуралд хүргүүлэн MNS 6982 : 2022 стандартыг батлуулсан.	100%	100%
1.3. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.										
1.3.1	“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, хэрэгжүүлэх боломжгүй болон хэрэгжилт хангалтгүй зүйл, заалтыг тодорхойлж, нэмэлт өөрчлөлтийн санал боловсруулж, танилцуулах;	Хувиар	Хуулийн төслийн шинэчилсэн найруулга батлагдаж эрх зүйн орчин боловсронгуй болно	10%	50%	I-IV	ЗСХ	“Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, ХХААХҮЯ, УИХ-ын Тамгын газрын шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн.	100%	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 2: Биржийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх										
2.1. Биржийн бүтэц зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, бүтцийн шинэчлэл хийж, ажлын үр дүнг нэмэгдүүлнэ.										
2.1.1	Биржийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, шинэчлэх;	Хувиар	Биржийн дунд хугацааны стратегийн баримт бичгийг хэрэгжүүлэх суурь нөхцөл болсон хүний нөөцийн бааз суурьт түшиглэсэн үйл ажиллагааны оновчтой бүтэцтэй болсон байх	10%	100%	I	ЗСХ, АЗЗХХ	Компанийн Бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарим нэгжийн чиг үүрэг, зарим ажлын байрыг өөрчлөх хэрэгцээ шаардлага үүссэн тул Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 16 дугаар тогтоол, Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3, 14.4.5-д заасныг тус тус үндэслэн компанийн бүтэц, орон тоог 5 хэлтэс, 38 ажилтантай шинэчлэн баталсан. Бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан ажлын байрны тодорхойлолт, Хөдөлмөрийн дотоод журам, Хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, батлуулсан. Шинэчлэн баталсан бүтэц, орон тооны дагуу ажиллах этгээдийг нээлттэй сонгон шалгаруулалт явуулах замаар томилсон.	100%	100%
2.2. Боловсон хүчний бодлого, төлөвлөлт, нийгмийн оролцоо, хувь хүний хөгжил, цалин урамшуулал, идэвхжүүлэлт бүхий биржийн хүний нөөцийн цогц бодлого, төлөвлөлтийн төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд										
2.2.1	Хүний нөөцийн бодлогын баримт бичиг-ийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх;	Хувиар	Бодлогын баримт бичиг	10%	100%	I	ЗСХ	Гүйцэтгэх захирлын 6 дугаар сарын 24-ний өдрийн А/64 дугаар тушаалаар Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг батлуулав.	100%	100%
2.2.2	“Ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, ажлын үр дүнг үнэлж, дүгнэх журам” боловсруулах;	Хувиар	Эрх зүйн баримт бичиг	10%	100%	I	ЗСХ	Компанийн Хөдөлмөрийн дотоод журмын 11 дүгээр бүлэгт ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, ажлын үр дүнг үнэлж дүгнэх журмыг нэмэлт өөрчлөлтөөр оруулж батлуулав.	100%	100%
2.3. Биржийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах										

2.3.1	Сошиал медиа олон нийтийн сүлжээг хөгжүүлж үүгээр дамжуулан үйл ажиллагаагаа таниулах, мэдээ мэдээллээр хангах;	Хувиар	Сурталчилгааны мэдээлэл	мэдээ	20%	100%	I-IV	A33XX, ЗСХ	Компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, мэдээ мэдээллээр хангах, цахим хуудсыг хөгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын албан ёсны цахим хуудсанд цаг үеийн мэдээ, мэдээлэл, арилжааны мэдээ, оны онцлох үйл явдал, танин мэдэхүй, олон улсын мэдээ зэрэг мэдээ мэдээллүүдийг цаг алдалгүй долоо хоногийн тухайн өдөр бүр системтэйгээр түгээж ажиллаж байна. 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн компанийн албан ёсны цахим хуудасны нийт хандалтын тоо 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 109,736 болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 2870 гаруй хувиар өссөн байна. Энэ онд цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэхдээ нийт 181 зурган, видео болон текст мэдээ нийтэлсэн. Мөн цахим хуудасны дагагчдын тоог нэмэгдүүлэх зорилтын хүрээнд ямар нэгэн нэмэлт төлбөр төлөлгүйгээр зөвхөн органик хэлбэрээр өсгөх зорилгоор Marketing community нэртэй нийт ажилтнуудын чат дунд групп нээж дотоодын нөөц боломжийг ашиглан ажилчдын дэмжлэгтэйгээр богино хугацаанд 3024-аар нэмэж ажилласан нь өмнөх оны мөн үетэй харьцуулвал 1465 гаруй хувиар өссөн байна. Цахим хуудсанд хандах хандалтыг цаг алдалгүй хариу өгөх, хэрэглэгчдэд мэдээ мэдээллээр хангах, харилцагчдын түгээмэл асуух асуултад хариулах зорилгоор автомат хариулагч суурилуулан цахим хуудсаа хөгжүүлж ажиллаж байна. Олон нийтэд мэдээ, мэдээллийг түгээх, сурталчлах цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор shuurhai.mn, ergelt.mn, medee.mn, newslife.mn, tsenzuur.mn, arslan.mn зэрэг мэдээний сайтуудтай гэрээ байгуулж мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэж байна. ХХААХҮЯ-ны мэдээллийн ажилтантай хамтран яамны вебсайт tofa.gov.mn болон цахим хуудас, zarig.mn, itoim.mn сайтуудаар мөн орон нутгийн ХАА-н салбар газар, хоршоо,	100%	100%
2.3.2	Зорилтот зах зээлийн хэрэглэгчдэд чиглэсэн контент маркетинг хийх;	Тоогоор	Контент		1	3	I-IV	A33XX, ЗСХ	Малчин хоршоогоор дамжуулан хэрхэн биржийн арилжаанд оролцох вэ? Биржийн арилжаа хэрхэн явагддаг вэ? нэртэй 2 видео контентыг 2D анимац хэлбэрээр хийж гүйцэтгэсэн. Малчин, хоршоодод чиглэсэн видео контентыг олон нийтэд цахим хуудас, яамны хэвлэл мэдээлэл, мэдээний сайтуудаар түгээсэн. Биржийн арилжаа хэрхэн явагддаг вэ? видео контентыг ноосны арилжаа эхлэхийн өмнө олон нийтэд хүргэхээр төлөвлөсөн. Мөн "Сумандаа сайхан амьдаръя" нэвтрүүлэгтэй хамтран хоршооны үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор хамтран ажиллаж эхэлсэн ба нийт 10 цуврал нэвтрүүлгээс эхний 6 дугаарыг Малчин ТВ, Youtube сувгуудаар 2022 оны 04 дүгээр сарын 21-ны өдрөөс эхлэн орон даяар нэвтрүүлсэн.	100%	100%
2.4. Биржээр арилжих жагсаалтад орсон бараа, түүхий эдийн арилжааг идэвхжүүлж, нэр төрлийг нэмэгдүүлж зах зээлийг өргөжүүлнэ.											
2.4.1	Ямааны ноолуур, хонь, тэмээний ноос, завод ноос, тосны ургамлыг биржээр арилжих тогтолцоог сайжруулах нөхцлийг бүрдүүлж, оролцогчдыг нэмэгдүүлэн, арилжааг зохион байгуулах;	Тоогоор	Арилжаа		135	150	I-IV	A33XX, ТТЭУХ, ГБХ, ЦХАХХ, ЗСХ	10 дугаар сарын 25-ний өдрийн байдлаар 7 нэр төрлийн бараа, түүхий эдийн арилжааг 150 удаа, нийт 1 их наяд 70 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа зохион байгуулсан байна. Оролцогчдыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Биржийн зах зээлд оролцогчдод мэдээ, мэдээллийг түргэн шуурхай хүртээмжтэй байдлаар хүргэх зорилгоор Facebook сошиал сүлжээнд групп үүсгэж, зах зээлд оролцогчдод мэдээлэл өгч группт урьж ажиллаж байна. Энэ оны байдлаар 11 ААН, 3 Хоршоо шинээр бүртгүүлэн биржийн арилжаанд оролцсон байна.	100%	70%
2.4.2	Арьс шир биржээр арилжих нөхцлийг боловсронгуй болгож цаашид хэрхэн арилжааг нэмэгдүүлэх судалгаа боловсруулж, санал боловсруулах;	Хувиар	Судалгааны ажил		80%	100%	I-II	A33XX	Арьс шир биржээр арилжих нөхцөлийг боловсронгуй болгож цаашид хэрхэн арилжааг нэмэгдүүлэх судалгааны ажлын хүрээнд арьс ширний түүхий эдийн нөөц, дотоодын хэрэглээ, түүхий эдийн экспортод хууль эрх зүй болон бусад талаас нөлөөлөх хүчин зүйлс, хүндрэл бэрхшээлүүдийг судлан санал боловсрууллаа.	100%	70%

2.4.3	Хөдөө аж ахуйг дэмжих сангийн ер төлбөрт авсан хүнсний улаанбуудайг биржээр арилжих;	Тоогоор	Арилжаа	0	5	I-IV	АЗЗХХ, ЦХАХХ, ТТЭУХ, ГБХ,ЗСХ	2021 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн А/33 тоот тушаалаар байгуулагдсан "Улаан буудайн дамжуулан худалдах, дериватив зах зээлийн судалгааны ажлын зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах" тендэрт "Бодлогын Шийдэл" ТББ шалгаран судалгааг хийж гүйцэтгэн 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хүлээлгэн өгсөн. Судалгааны тайланд ХААБ дээр улаан буудайн спот болон фьючерс арилжаа хийх боломжийн талаар судлан дүгнэлт гарган яам болон биржийн удирдлагуудад танилцуулсан. Дүгнэлтээр улаан буудайг арилжихад ХААДС-ын агуулахын хүртээмж муу байгаагаас тариаланчид тариалсан буудайгаа шууд гурилын үйлдвэрт үнэ тохирон борлуулж байна. Иймд бирж буудайн арилжааг хийхэд тариаланч болон гурилын үйлдвэрүүдэд сурталчилгаа, маркетинг хийх зэргээр бэлтгэл ажлыг сайн хангах шаардлагатай байна гэж дүгнэсэн.	100%	70%
2.4.4	Амьд малыг загвар хоршоогоор дамжуулан биржээр арилжих нөхцөлийг судлах, бэлтгэл ажлыг хангаж, арилжааг эхлүүлэх;	Тоогоор	Малын тоо толгой	0	20	I-IV	АЗЗХХ, ТТЭУХ, ГБХ, ЦХАХХ, ЗСХ	<p>1. Махны судалгааны үр дүн дээр үндэслэн махны үйлдвэрүүдээс ирүүлсэн нөхцөл шаардлагын дагуу биржийн байнгын бус гишүүн хоршоодоос амьд мал бэлтгэн нийлүүлэх ажлыг эхлүүлэхээр "Мах маркет" ХХК- тай хамтран туршилтын арилжааг хийхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2. 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Шилмэл мал- 2022 цахим үзэсгэлэн, үнэ хаялцуулах дуудлага худалдааны зохион байгуулалтын багт оролцож ажилласан бөгөөд дуудлага худалдаанд 4 аж ахуй нэгж, 3 иргэний 19 толгой мал оролцсоноос дуудлага худалдаагаар 3 толгой үхэр, 1 толгой адуу, 2 толгой адуу худалдаалагдсан. 3. Мөн 2022 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Говь-Алтай аймгийн Баян-Уул суманд амьд малын онлайн дуудлага худалдаа, амьд малын спот гэрээний туршилтын арилжаа зохион байгуулагдан арилжаанд Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын "Санжин Богд" хоршоо болон "Зайсан Инвест Агро" ХХК оролцсон. Амьд малын онлайн дуудлага худалдаанд "Санжин Богд" хоршооноос өсвөр насны 200 толгой хонь, нас бие гүйцсэн 50 толгой эм хонь дуудлага худалдаанд оролцуулахад "Зайсан Инвест Агро" ХХК цахимаар холбогдож, худалдан авах хамгийн дээд үнийн санал өгч дуудлага худалдааны ялагч боллоо. Амьд малын спот гэрээний арилжаанд "Санжин Богд" хоршоо нийт 100 толгой мал худалдах санал ирүүлснээс "Зайсан Инвест агро" ХХК 1 удаагийн хэлцлээр 20 толгой нас гүйцсэн эр хонь худалдан авсан үр дүн гарав.</p>	100%	100%

2.4.5	Махыг биржээр арилжих боломжийг судалж, санал боловсруулах;	Хувиар	Судалгааны ажил	60%	100%	I	A33XX	Махыг биржээр арилжих боломжийг судалж, санал боловсруулах ажлын хүрээнд 17 аймаг болон нийслэлийн 66 махны үйлдвэрийн 74 хувь буюу 49 махны үйлдвэртэй холбогдон үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, хоршоодоор дамжуулан мах худалдан авах сонирхолтой эсэх, мах хоршоодоор авбал аль аймгаас авах зэргээр санал асуулга хэлбэрээр асууж мөн нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа 5 махны үйлдвэрийн төлөөлөлтэй очин уулзаж бодит байдлыг сонсох, мах хоршоодоос худалдан авахад тавигдах шаардлага юу байгааг тодруулсан. Судалгааны дүгнэлтэд үйл ажиллагаа явуулж байгаа болон улирлын чанартай явуулдаг нийслэл, 16 аймгийн нийт 42 махны үйлдвэрийг мах нийлүүлэх боломжтой байна. Үүнийг лавтан 14 үйлдвэрийн 6125 тн бог мал, 1625 тн бод малын стандарт шаардлага хангасан махыг хоршоодоос худалдан авах сонирхолтой байсан ба үүнээс "Мах маркет" ХХК "Агро нэгтгэл трейдинг" ХХК, "Цалуут Импекс" ХХК нар хамтран махны арилжааг зохион байгуулан хүндэрч болох бэрхшээл, саад юу тулгарах нь уу, хэрхэн шийдэх боломжтой талаар хамтран ажиллахаа илэрхийлсэн. Гүйцэтгэх захирлын 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн А/48 тоот тушаалаар Засгийн газраас 2022 оныг "Хоршооны хөгжлийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан малчид, хоршоод, аж ахуй нэгжээс амьд мал, махыг биржийн арилжаанд оруулан дотоодын боловсруулах үйлдвэрт нийлүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулж байнгын холбоотой ажиллаж байна.	100%
2.5. Биржийн "Гэрээний стандарт"-ыг сайжруулах замаар зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлнэ.									
2.5.1	"Фьючерс гэрээ"-ээр арилжих боломжтой бараа, түүхий эдийн судалгааг гаргаж, "Гэрээний стандарт" загварыг боловсруулах;	Тоогоор	Эрх зүйн баримт бичиг	0	2	I-IV	A33XX, ТТЭУХ, ГБХ, ЦХАХХ, ЗСХ,	Фьючерс гэрээний стандарт загвар, Худалдах, худалдан авах гэрээний төслийг шинээр боловруулах, фьючерс арилжаа зохион байгуулах журмын төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг 2021 оны Гүйцэтгэх захирлын А/57 тоот тушаалаар байгуулагдсан ба Дэд захирал Б.Саруул ахлан ажилласан. Тус ажлын хэсэг "Фьючерс гэрээний стандартын загварыг боловсруулсан ба тус гэрээгээр арилжигдах боломжтой бараа, түүхий эдийн судалгаа хийгдэж дууссаны дараагаар бараа, түүхий эдийн нэр төрлөөс шалтгаалан төрөл тус бүрээр боловсруулах шаардлагатай байгаа тул хүлээгдэж байна. Мөн худалдах, худалдан авах гэрээг шинэчлэн клиринг, төлбөр тооцооны журмын хавсралтаар батлагдсан.	90%
2.6. Клиринг, төлбөр тооцооны олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалыг нэвтрүүлж, зах зээлд оролцогчдын эрсдлийг бууруулах, төлбөр тооцоог эрсдэлгүй түргэн шуурхай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.									
2.6.1	Спот гэрээний дэнчин тооцоолох шинэ арга, аргачлал, төлбөр тооцоог хялбаршуулах, хурдан шуурхай гүйцэтгэх боломжийн талаар санал боловсруулах;	Хувиар	Арга аргачлалыг шинэчлэх судалгааны ажил	0%	100%	I-IV	ТТЭУХ, A33XX	1. Банкуудын шалгуур үзүүлэлтийг тогтоож, харьцуулсан судалгааг гаргасан. 2. Мөн гишүүн оролцогчдод зориулсан шаардлагатай гарын авлагыг боловсруулан вэб хуудаст байршуулсан. 3. Спот гэрээний арилжаанд хэрэглэгдэж буй дэнчин, барьцаа хөрөнгийн тооцоолол зохистой эсэх, шинэчлэх шаардлагын талаар олон улсын биржүүдийн харьцуулсан үзүүлэлтийг оруулан судалгааг боловсруулж, бууруулах шаардлагатай гэж үзэн, танилцуулсан.	100%
2.6.2	"Фьючерс гэрээ"-ний дэнчин тооцоолох шинэ арга, аргачлал, төлбөр тооцоог гүйцэтгэх оновчтой аргыг тодорхойлж, санал боловсруулах;	Хувиар	Судалгааны ажил	0%	60%	III-IV	ТТЭУХ, A33XX	Биржийн хөгжил улсын хэмжээнд хангалтгүй байгаагаас үүдэн мэдээлэл, боловсон хүчин, туршлага дутмаг зэргээс шалтгаалан олон улсын туршлага судлах, зөвлөгөө авах зайлшгүй шаардлагатай байна. Мөн бусад улсын жишгийг харьцуулан авч үзэхэд манай улс нь фьючерсийг нэвтрүүлэх нь эрт буюу суурь нь бэлтгэгдээгүй байгаа юм. Иймд урьдчилсан байдлаар харьцуулалтыг хийж, боломжит аргуудаар санал боловсруулсан.	90%
2.7. Биржийн "Эрсдлийн удирдлагын төлөвлөгөө"-г боловсруулж, хяналт, мониторингийн тогтолцоог хэрэгжүүлнэ.									

2.7.1	Хяналт, мониторингийн тогтолцоог хэрэгжүүлэх, олон улсад нийтлэг мөрдөгддөг зарчмын дагуу холбогдох журмын төслийг хэлэлцүүлж батлуулж, мөрдөх;	Хувиар	Эрх зүйн баримт бичиг	10%	60%	I-IV	ЗСХ	1. Эрсдэлийн сангийн журмын төслийг ТТЭУХ-ийн зүгээс боловсруулан, эрсдэлийн сангийн бүрдүүлэлт, хувь хэмжээг тогтоох зарцуулалт зэрэг нарийн асуудал дээр зөвлөгөө авах шаардлагатай гэж үзэж, зөвлөх үйлчилгээ авах ажлын даалгавар дээр нэмэлтээр тусгахаар болсон бөгөөд Зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэгч зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагад хүргүүлж, шаардлагатай мэдээллээр хангасан. 2. "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мэдээлэх үйл ажиллагааны журам" -ын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий албан тушаалтнаар Төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн М.Түмэнбуянг томилов. 3. "Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх" дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр боловсруулав.	90%	70%
2.7.2	Биржийн зах зээлийн эрсдлийг тодорхойлж, үнэлэх, урьдчилан таамаглах арга, аргачлал бүхий "Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө" боловсруулж, хэрэгжүүлэх;	Хувиар	Эрх зүйн баримт бичиг	10%	60%	I-IV	ТТЭУХ	1. ТТЭУХ-ээс байгууллагын эрсдэлийг тодорхойлж, үнэлгээг гаргасан. 2. Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх арга хэмжээ буюу төлөвлөгөөг гарган, хэлтсүүдэд хүргүүлсэн. 3. "Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг" -ийг боловсруулж, батлуулсан. 4. Тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, үр днг тайлагнах, баталгаажуулах чиг үүргийн хүрээнд "Эрсдэлийн удирдлагын хороо"-г гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан ажиллаж байна. 5. Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдэд мэдээлэл өгч, ажил үүргийн хувиарлалтыг хийв. 6. Нийт ажилтнуудад эрсдэлийн удирдлагыг байгууллагын соёлд нэвтрүүлэх чиглэлийн хүрээнд танилцуулга, мэдээлэл хүргэж ажиллав. Эрх зүйн баримт бичгийн хүрээнд энэхүү ажил зорилтот түвшинд хүрсэн бөгөөд цаашид хэрэгжүүлэлтэд үнэлэлт, дүгнэлтийг хийх, хэрэгжилтийг гарган ажиллаж байна. 7. Эрсдэлийн удирдлагын хорооны ээлжит хурлуудыг зохион байгуулж, байгууллагын эрсдэлийг бүртгэлжүүлж, шаардлагатай авах арга хэмжээ, зөвлөмжийг боловсруулж хэлтсүүдэд хүргүүлж байна.	90%	70%
Стратеги төлөвлөгөөний зорилго 3: Биржийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх										
3.1. Гадаад болон дотоодод хэрэгжиж буй төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах, бусад орны биржүүдтэй харилцах хамтын ажиллагааг үр ашигтай өргөжүүлнэ.										
3.1.1	НҮБ-н дэргэдэх Тогтвортой санаачлагад элсэх шаардлагуудыг өргөдөл гаргах;	Тоогоор	НҮБ-н дэргэдэх Тогтвортой биржийн санаачлагад элсэх хүсэлт бүхий өргөдлийг 2022 онд тус холбоонд хүргүүлсэн байна.	0	1	I-IV	A33XX	7 дугаар сарын 12-ны өдөр гишүүнээр элсэн тус байгууллагын вебсайтад Монголын ХААБиржийг гишүүнээр элсүүлсэн талаар мэдээ нийтлэгдсэн. (Мэдээний линк: https://sseinitiative.org/all-news/the-mongolian-agricultural-commodity-exchange-joins-the-un-sse-derivatives-network/)	100%	100%

3.1.2	Монгол Улсад хэрэгжиж буй хөдөө аж ахуйн салбарын хөрөнгө оруулалт, үүсмэл санхүүгийн хэрэгсэл болон зохицуулалттай зах зээлийн хөгжилд чиглэсэн гадаад болон дотоод төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах боломжийн талаар санал боловсруулах, хамтран ажиллах;	Тоогоор	Төсөл хөтөлбөртэй хамтрах	3	5	I-IV	A33XX	<p>1. ОХУ-ын Русская кожа хамтын нийгэмлэгийн төлөөлөгчдийн 2022 оны 1 дүгээр сарын 14-22-ны өдрүүдэд Монгол Улсад хийсэн албан томилолтын бэлтгэл ажлыг хангаж, томилолтын хөтөлбөрийн дагуу арга хэмжээг зохион байгуулав. Русская кожа хамтын нийгэмлэгийн төлөөлөгчид холбогдох байгууллагуудтай санал солилцсон ба Үйлдвэр худалдааны "Өлзийт төв" ХХК-с 20 тн нойтон, давсалсан арьс ширийг дээж хэлбэрээр худалдан авсан үр дүн гарсан.</p> <p>2. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжих Монголын хөдөө аж ахуйн биржид эрх зүйн туслалцаа үзүүлэх техник туслалцааны ажлын даалгавар боловсруулах, ажлын даалгаварт тусгагдсан ажлуудын хүрээнд хийгдэх дэд ажлуудын дэлгэрэнгүй жагсаалтыг тус тус боловсруулан Биржийн зүгээс 10,0 сая ам.долларын санхүүжилт хүсч тус санхүүжилтийг зарцуулах ажлын танилцуулгыг хүргүүлсэн байдалтай байна. Тус төсөл 2023 оны 01 дүгээр сараас эхлэн хэрэгжихээр хүлээгдэж байна.</p> <p>3. Турк улсын ХААБиржүүдэд 2022 оны 11 дүгээр сарын 20-27 өдрийн хооронд Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын ажилтай холбогдуулан нэр бүхий УИХ-ын гишүүд, ХХААХҮЯамны төлөөлөл, Хөдөө аж ахуйн биржийн төлөөлөл зэрэг албаны бүрэлдэхүүнтэйгээр Турк улсын худалдааны бирж (TURIB), Измирийн таваарын бирж, Полатлы таваарын бирж болон холбогдох итгэмжлэгдсэн агуулах, лаборатори, мах бэлтгэлийн үйлдвэр зэрэг байгууллагуудад туршлага судлах айлчлалыг зохион байгууллаа. Энэ хүрээнд Турк улсын худалдааны бирж (TURIB)-тэй цаашид туршлага солилцох, хамтарч ажиллах санамж бичиг байгуулав.</p>	100%	100%
3.1.3	Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн уялдаа холбоог судлах, хамтран ажиллах;	Хувиар	Судалгааны ажил	0	100%	I-IV	A33XX	<p>НҮБ-ын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн нэмэлт санхүүжилтийг зорилтот 9 аймгаас сонгогдсон хөдөө аж ахуйн хоршоодод дэмжлэг үзүүлэх зорилгоор Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийг Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, Монголын Хөдөө аж ахуйн бирж ХХК нар харилцан тохиролцож хамтран ажиллах санамж бичгийг байгуулсан.</p>	100%	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 4: Мэдээлэл технологийн цахим шинэчлэлт хийх										
4.1. Биржийн дотоод үйл ажиллагаа, арилжаа, клиринг, төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах тоног төхөөрөмжөөр хангах.										
4.1.1	Биржийн дотоод үйл ажиллагаанд ашиглагдах програм хангамжийг сайжруулж, сүлжээний найдвартай байдлыг хангах;	Хувиар	Программ шинэчлэлт хангамжийн	0%	100%	I-IV	ЦХАХХ, ЗСХ	<p>1. Ай түүлс ХК-тай байгуулах блокчейн технологид суурилсан арилжаа, төлбөр тооцооны иж бүрэн систем ашиглалт, үйлчилгээний гэрээг албан ёсоор байгуулаад үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Арилжааны системийн өгөгдлийн сангийн oracle баазыг postgres баазруу шилжүүлэх ажил төлөвлөгөөний дагуу явагдаж байгаа бөгөөд гүйцэтгэл 90%-тай байна.</p> <p>Нэмэлт гэрээний хүрээнд хийгдэх ажлууд (Форвард, Опцион гэрээний үдийн дүрэм журам урьдчилсан байдлаар боловсруулж Айтүүлс ХК-тай санал солилцон хэрэгжүүлэх тал дээр хамтран ажиллахаар боллоо. Арилжаа төлбөр тооцооны иж бүрэн системийн нэмэлт ажлуудын хүрээнд 20 ажлыг хийж гүйцэтгэхээр тохиролцсон бөгөөд хийгдэж байгаа шатандаа явж байгаа 18 ажлыг засварыг хийж дуусгасан байна.</p>	90%	70%

4.1.2	Биржийн дотоод техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийж, нөөц бүрдүүлэх;	Хувиар	Систем, тоног төхөөрөмжийн шинэчлэлт	20%	100%	I-IV	ЦХАХХ, ЗСХ	Биржийн дотоод техник тоног төхөөрөмжийн шинэчлэл сүүлийн 5 жилийн хугацаанд дорвитой хийгдээгүй байсан бөгөөд 2022 онд байгууллагад шинээр тоног төхөөрөмж худалдан авах төлөвлөгөөг гаргаж хэрэгтэй тоног төхөөрөмжүүд худалдан авч шинэчлэлийг хийгээд байна. Үүнд: сүлжээнд ашиглах хэвлэх төхөөрөмж, свич 16 порт, 4 порт, утасгүй сүлжээний төхөөрөмж, тог баригч, мэргэжлийн зургийн аппарат дагалдах хэрэгсэл, прожектор, ухаалаг самбар, суурин компьютер, хэрэглээний програм (Office 365 30 ширхэг) , компьютерын вирусны програм (Kaspersky Endpoint 20 ширхэг) зэргийг худалдан авч тохиргоо хийж ажилчдад хүлээн өглөө. Дотуур холбоо сайжруулах чиглэлийн хүрээнд мэргэжлийн байгууллагатай холбогдож тохиргоо хийлгэн хэлтсүүд, өрөөнүүдэд холбож тус бүр дээр дотоод дугаар өгч, гарын авлагууд хэрхэн ашиглах талаар зааварчилгаа өгч ажиллаа. Нөөц бүрдүүлэхтэй холбоотойгоор active director системийг шинэчлэх физик серверийн техник эдийн засгийн үндэслэл, худалдан авалтын үнийн дүнг худалдан авах ажиллагааны газарт гаргаж өглөө.	100%	100%
4.1.3	Биржийн веб сайтыг шинэчлэх	Хувиар	Цогц мэдээлэл бүхий цахим хуудас	20%	100%	I-II	ЦХАХХ, ЗСХ	1. Биржийн цахим хуудсыг шинэчлэхтэй холбоотой "Про крафт" ХХК-тай гэрээ байгуулж UXUI дизайны ажлыг хийж 8 удаагийн танхим болон онлайн уулзалтыг хийж санал бодлоо солилцож загвараа баталж, Ай түүлс ХК-тай ашиглалт үйлчилгээний гэрээ хийгдсэнээр UXUI загварын дагуу веб сайт хөгжүүлэлтийн ажил эхлээд хийгдэж дууслаа. Хөгжүүлэлт хийсэн загварын дагуу байгууллагын мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. Ингэснээр байгууллагын үйл ажиллагааг иргэдэд нээлттэй цахим хэлбэрээр хүргэх, мэдээ мэдээллийг цаг алдалгүй авах нөхцлийг бүрдүүлэн ажиллаа. Цахим хуудас хэвийн үйл ажиллаж байна.	100%	100%
4.2 Цахим шинэчлэлтийг хийх ажлын хүрээнд биржийн дэд бүтцийг хөгжүүлэхэд ашиглагдах дэд системүүдийг бий болгоход шаардлагатай тооцоо, судалгааг гаргах, боломжит системийг нэвтрүүлнэ.										
4.2.1	"Агуулах бүртгэлийн нэгдсэн систем"-ийн үр ашгийг тооцоолох, хөгжүүлэлт хийх, нэвтрүүлэх;	Тоогоор	Агуулах бүртгэлийн нэгдсэн систем	0	1	I-IV	ЦХАХХ, ЗСХ	1. JICA олон улсын байгууллагаас жишиг хоршоо болон биржийн агуулах бүртгэлийн системийн (Rfid tag) дэлгэрэнгүй танилцуулга хийж танилцуулсан. 2. "Агуулах бүртгэлийн систем"-ийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн ажлыг дахин судалгаа хийж, хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй, програм хангамжийг хийхээр зорьж байна. Программ хангамжийн судалгааг дутуу хийсэнээр хэрэглэгчдэд ойлгомжгүй байдал үүсэх эрсдэл үүсч байгаа тул судалгааг дахин хянаж, хийхээр төлөвлөн ажиллаж байна.НҮБ-ийн ADAPT төслийн хүрээнд ХХАХҮЯ-тай хамтран төслийн модулиудыг хүргүүлсэн. Холбогдох баримт бичгийг дахин Дижитал медик ХХК-иас өгөөд байна. /50%/	50%	30%
Стратеги төлөвлөгөөний зорилго 5: Биржийн зах зээлд оролцогч руу чиглэсэн тэнцвэртэй бодлого хэрэгжүүлэх										
5.1. Биржийн арилжаанд оролцогч гишүүдийг чадавхжуулах, тэдгээрийг идэвхжүүлэх, нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.										

5.1.1	Биржийн байнгын гишүүн оролцогчдыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд судалгаа хийж, түүнд үндэслэн холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, хамтран ажиллах, сурталчилгаа явуулах, биржийн арилжааг сонирхогчдод түшиглэн оролцогчдын тоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх;	Тоогоор	Байнгын гишүүн	6	7	IV	ГБХ, АЗЗХХ	Судалгааны ажил хийгдсэн. Биржийн арилжаа сонирхогч этгээдэд зориулсан Брокерын сургалтыг Санхүүгийн зохицуулах хороотой хамтран зохион байгуулахаар сургалтын хөтөлбөрийг боловсруулан СЗХ-нд хүргүүлсэн. СЗХ-оос манай хөтөлбөрийг баталсан. Сүүлийн байдлаар Холбоотой гэрээ байгуулж, сургалт хийх ажил хүлээгдэж байна. Сургалтад хамрагдах хүсэлтээ өгсөн иргэн аж ахуй нэгж, хоршооноос гадна "Цэцүүн агь" ХХК нь биржийн байнгын гишүүнээр элсэх хүсэлтэй байгаа ба Брокерын эрх олгох сургалтын дараа холбогдох бичиг баримтийг бүрдүүлэн биржид ирүүлэхээр тохирсон.Биелэлт-100%	100%	100%
5.1.2	Биржийн байнгын бус гишүүн оролцогчдыг нэмэгдүүлэх, идэвхижүүлэх ажлын хүрээнд судалгаа хийж, түүнд үндэслэн холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулах, хамтран ажиллах, сурталчилгаа явуулах, тохирох идэвхжүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх;	Тоогоор	Байнгын бус гишүүн	2	10	I-IV	ГБХ, АЗЗХХ	Төв, Өвөрхангай, Архангай, Хэнтий, Баян-Өлгий, Сүхбаатар, Дорнод, Ховд, Дундговь, Хөвсгөл, Говь-Сүмбэр, Говь-Алтай аймгуудын "Орлогын овоо цээл", "Явын булаг", "Олон ширээ", "Баялаг гүрэм", "Хонгор арвижих", "Түмний буян далай", "Нүүдэлчдийн хөгжлийн гараа", "Малчдын хамтын хүч" "Тэргүүн богд" "Ялгуусан эрхэт" "Дэлгэрэх хөвийн дэвшил" зэрэг 27 хоршоог гишүүнээр бүртгэж, гэрээ байгуулан арилжааны програмд бүртгэл үүсгэсэн. 2022 онд нийт 17 удаагийн сургалт, сурталчилгаа зохион байгуулж, нийт 943 хүнд танилцуулга, мэдээлэл хүргэн, 115 хоршоонд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 71 хоршоог биржийн байнгын бус гишүүнээр бүртгэж, гэрээ байгуулаад байна. Биелэлт 100%	100%	100%
5.1.3	Биржийн арилжаанд оролцогч гишүүдийг холбогдох мэргэжлийн байгууллага, холбоодтой хамтран мэргэшүүлэх, эрх олгох сургалтын хөтөлбөр боловсруулж, зохион байгуулах;	Тоогоор	Мэргэшүүлэх, эрх олгох сургалт	0	2 удаа	II болон IV	ГБХ	1.Байнгын бус гишүүн "Орлогын овоо цээл", "Явын булаг", "Олон ширээ", "Их шижи" хоршоонд агуулах болон арилжааны програмын сургалт хийсэн. "Код олгогч"-ийн сургалтад "Түмний буян далай", "Нүүдэлчдийн хөгжлийн гараа", "Явын булаг", "Орлогын овоо цээл", "Төв Өндөрширээт" хоршоог хамруулсан. Хөдөө аж ахуйн бирж, Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд "Хоршоодыг чадавхижуулах, биржийн зах зээлийн мэдлэг олгох" цогц сургалтыг 2022 оны 06 сарын 15-наас 17-ны өдрүүдэд Хоршоологчдын холбооны байрны 4 давхарт хийлээ. Сургалтад 12 хоршооны удирдлага, 20 суралцагч хамрагдаж гэрчилгээ олгосон бол агуулахын ажилтан 12 хоршооны ажилтанд "Биржийн барааны кодлогч"-ийн эрхийн үнэмлэх гардуулж, дадлага хичээлийг "Лора Пиано Монголиа" ХХК-ийн үйлдвэрийн агуулах, "Сор Кашмер" ХХК-ийн үйлдвэрийн дамжлага дундын үйл ажиллагаатай танилцуулсан. системийн нэмэлт ажлуудын хүрээнд 20 ажлыг хийж гүйцэтгэхээр тохиролцсон бөгөөд хийгдэж байгаа шатандаа явж байгаа 18 ажлыг засварыг хийж дуусгасан байна.н гишүүд, ХХААХҮЯамны төлөөлөл, Хөдөө аж ахуйн биржийн төлөөлөл зэрэг албаны бүрэлдэхүүнтэйгээр Турк улсын худалдааны бирж (TURIB), Измирийн таваарын бирж, Полатлы таваарын бирж болон холбогдох итгэмжлэгдсэн агуулах, л	100%	100%
5.2. Малчин, тариалан эрхлэгчдийн оролцоог идэвхжүүлж, арилжаанд оролцох боломжийг бүрдүүлэн орлогыг нэмэгдүүлнэ.										

5.2.1	Биржийн боловсруулсан "Загвар хоршоо"-ны төсөл, техник эдийн засгийн үндэслэлийн дагуу (Хэнтий аймгийн Баян-Овоо сум) загвар хоршоог бий болгоход удирдлага арга зүйн зөвлөгөө өгөх, хөгжүүлэх, арилжаанд оролцох нөхцлийг бүрдүүлэх;	Тоогоор	Загвар хоршоо	0	1	I-IV	ГБХ, АЗЗХХ, ТТЭУХ, ЦХАХХ, ЗСХ	"Баялаг гүрэм" загвар хоршооны гишүүдээс 100 богц ноолуурыг бэлтгүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, "Сор кашимер" ХХК-д борлуулах арилжааг зохион байгуулсан.Төв аймгийн Аргалант сумын "Хонгор арвижих" хоршоо нь Ложистикийн төвөөс биржийн арилжаанд оролцож, 77 богц буюу 770 кг боловсруулаагүй цайвар ноолуур "Эм Кэй Бай" ХХК-д арилжлаа. Байнгын бус гишүүнээс 2 удаа ноолуурын арилжааг зохион байгууллаа. "Баялаг гүрэм" хоршооны агуулахыг засварт шаардлагатай 19.3 сая төгрөгийг "JICA" ОУ-ын байгууллага, "Дорнод Монголын хуурай хээрийн тогтвортой ландшафт, биологийн олон янз байдлын хамгаалал төсөл"-өөс тус тус санхүүжүүлж засварын гүйцэтгэлийг хариуцаж гүйцэтгүүлсэн. Мөн 38 сая төгрөгийн үнэ бүхий хонь хяргах төхөөрөмжийг "Баялаг гүрэм" хоршоонд "JICA" ОУ-ын байгууллага хандивласан.	100%	100%
5.3. Гадаад болон дотоодын худалдан авагч, үйлдвэрүүдийг биржийн арилжаанд оролцох тэгш боломжоор хангах нөхцлийг бүрдүүлнэ.										
5.3.1	Гадаад болон дотоодын худалдан авагч, үйлдвэрүүдийг биржийн арилжаанд оролцох тэгш боломжоор хангах нөхцлийг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан бүрдүүлэх;	Хувиар	Судалгааны ажил	0	100%	I-IV	ГБХ, АЗЗХХ	Үндэсний үйлдвэр болох "Сор кашимер" ХХК-ийн төлөөлөл болон "Хан бүргэд Хэнтий" ХХК-ийн Ч.Амгаланбаатартай санал солилцсон. "Хүнс комплекс"ХХК-ийн удирдлагуудтай Гүйцэтгэх захирлын хамт уулзалт хийсэн. "Зайсан Инвест Агро" ХХК-ийн төлөөллийг Гүйцэтгэх захиралтай уулзуулсан. "Цалуут импекс"ХХК-ийн Санхүү бизнес хөгжил хариуцсан захирал О.Нэмэхбаяртай мөн "Мах маркет" болон Махны холбоотой уулзалт хийсэн. 2022 оны 10 дугаар сарын 21-ээс 25 хооронд "Зайсан Инвест Агро" ХХК-ийн төлөөлөлтэй Говь-Алтай аймагт хамтран ажиллаж, онлайн дуудлага худалдаа болон спот гэрээний туршилтын арилжааг амжилттай зохион байгуулсан.	80%	70%
Стратеги төлөвлөгөөний зорилго 6: Биржийн дэд бүтцийг сайжруулах										
6.1. Биржийн итгэмжлэгдсэн этгээдийн оролцоог нэмэгдүүлж, идэвхжүүлэн ложистикийн үйл ажиллагааг сайжруулна.										
6.1.1	Биржийн итгэмжлэл олгох үйл ажиллагааг зохион байгуулж, шалгуур үзүүлэлтийг хангасан итгэмжлэл хүсэгчид итгэмжлэл олгох;	Тоогоор	Ложистик удирлагын системд бүртгэгдсэн итгэмжлэгдсэн агуулах	33	40	I-IV	ГБХ	Ложистик удирдлагын програмд шинээр хүнсний буудайн 4, түүхий эдийн 5 нийт 9 агуулахыг бүртгэлжүүлсэн.	100%	100%
6.1.2	21 аймгийн сумдын ЗДТГ, ХААГ-тай орон нутагт биржийн итгэмжлэгдсэн агуулах бий болгох ажлын хүрээнд хамтран ажиллах;	Тоогоор	Орон нутагт итгэмжлэлийн шалгуур үзүүлэлтийг хангахуйц агуулахтай хийсэн гэрээ	76	100	I-IV	ГБХ	Шинээр Дорнод, Сүхбаатар, Дундговь аймгийн 11 хоршоог биржийн итгэмжлэгдсэн агуулахад тавигдах шалгуур үзүүлэлтийг хангуулж, анхан шатны баримт бичгийн бүрдэлийг бүрдүүлүүлэн бүртгэл хийж, гэрээ байгуулав. 2022 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 17 аймгийн 83 сумын 77 хоршоо, 17 аж ахуй нэгж, 12 иргэний нийт 106 агуулахтай итгэмжлэлийн гэрээ байгуулсан. Биелэлт-100%	100%	100%
6.1.3	Малын гаралтай түүхий эдийг чанар, стандартын шаардлагын дагуу бэлтгэн нийлүүлэх талаар сургалтыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах	Тоогоор	Бэлтгэгдсэн таваар бэлтгэгч	0	30	I-IV	ГБХ	Энэ оны эхний хагаст төлөвлөгдсөн Хэнтий аймгийн Баян-Овоо сумын "Баялаг гүрэм" хоршооны түүхий эд бэлтгэгч болох хүсэлт бүхий хоршооны гишүүд болон сумын ажилгүй иргэдэд зориулж "Таваар бэлтгэгч" бэлтгэх цуврал сургалтын "Ноолуур бэлтгэх технологи" сэдэвт сургалтыг 02 дугаар сарын 24-27-ны өдрүүдэд ХААИС-ийн ХААБТС-ийн доктор Л. Норовсүрэнгэй хамтран зохион байгуулж, амжилттай суралцсан 27 хүнд батламж гардууллаа.Мөн Арьс ширний салбарын сургалт, судалгаа, инновацийн "LEATHUB" төвийн нээлтийн үйл ажиллагаанд оролцож цаашид хамтран ажиллах талаар "Санамж бичиг"-т гарын үсэг зурсан Тус төслийн "Арьс ширний анхан шатны тордолт, чанарын хамгаалалт" сэдэвт сургалтад 2022 оны 06 дугаар сарын 20-оос 22-ны өдрүүдэд хамрагдаж сертификат авсан.	100%	100%
6.2. Ложистикийн төвийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ. Малын гаралтай бараа, түүхий эдийг бэлтгэх, чанарыг тодорхойлох, хадгалах, боловсруулах, тээвэрлэх болон бараа, түүхий эдийн танхимын арилжаа, амьд малын										

6.2.1	Ложистикийн төвийг үр ашигтай ажиллуулах нөхцөл байдлын судалгааг гаргаж, үйл ажиллагааг идэвхжүүлэх;	Хувиар	Ложистикийн төвийн үйл ажиллагаа	0	0.3	IV	ГБХ	Биржийн ложистикийн төвийг хэрхэн ажиллуулах тооцоолол хийн, түрээслүүлэх шийдвэрийг ТУЗ-өөс гаргуулан, түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг зохих журмын хүрээнд зохион байгуулж, "Зайсан Инвест Агро" ХХК-тай 3 талт түрээсийн гэрээ байгуулсан. Түрээслэгч тал ашиглалтын болон харуул хамгаалалтын зардлаа бүрэн хариуцах ба 2022 он дуустал сарын 3.0 сая, 2023 оноос 4.5 сая төгрөгийн түрээсийн төлбөр төлнө. Мөн тус төвийг барьсан "Түшиг арга" ХХК-ийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, үлдэгдэл төлбөрийн асуудлыг тохирч, гүний худгийн эвдрэл, шийт, гэрэлтүүлэг, монтаж, камерийг засуулсан.	100%	70%
-------	---	--------	----------------------------------	---	-----	----	-----	--	------	-----

Танилцсан: Гүйцэтгэх захирал

О.Нарандэлгэр

Биелэлтэд дүгнэлт хийсэн: Хяналт мониторингийн ахлах мэргэжилтэн

О.Сайнжаргал

Нийт	100%	90%	80%	50%
35	28	5	1	1
Хэрэгжилт -94,8%				

хэлтсүүдийн өөрсдийн үнэлгээний дүн

Нийт	100%	70%	30%
35	23	11	1
Хэрэгжилт -88.5%			